



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/᠖32

Алтай хот

**Уулзалт, хэлэлцүүлэг зохион  
байгуулахад хөрөнгө гаргах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1.Байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2.Шаардагдах 9,884,900 (Есөн сая найман зуун наян дөрвөн мянга есөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 31-ны өдрийн 11652 дугаар  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1.	"Алтай" хөх арвайн зоог	100 ширхэг	6,000	600,000
2.	Чонон хармаг /уут, савлагаа/	31 кг	63,000	1,953,000
3.	Ашвай	100 ширхэг	6,000	600,000
4.	"Алтай" Монгол сүүтэй цай	100 ширхэг	4,000	400,000
5.	Уут	115 ширхэг	4,500	517,500
6.	Бичиг хэргийн зардал	-	109,000	109,000
7.	Уулзалтын танхимын түрээс	4 цаг	5,705,400	5,705,400
Нийт дүн				9,884,900

\_\_оОо\_\_